

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/59/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 70483413 Цахим хаяг: Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn "Цэгц төв богд аудит" ХХК-ийн Ахлах аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГАНДМАНЬ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ч.БАТ-ЭРДЭНЭ
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 21

№

44

танай _____ -ны № _____ -т

Г Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Чандмань сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар тендерт шалгараагүй аж ахуйн нэгжээс эмийн худалдан авалт хийсэн, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, нягтлан бодох бүртгэлээрх эм, эмийн санчийн тайлангийн үлдэгдэлтэй тулгахад зөрүүтэй, үр дүнгийн урамшууллаас ангид урамшуулал олгосон, ээлжийн амралтын цалинг цалинтай давхардуулан олгосон, шилэн дансны цахим системд таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, өмнөх аудитын төлбөрийн актыг шатахууны зардлаас төлсөн зэрэг 18,136.3 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн 6.4, УСНББОУС-1-тэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2278 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилт 637,744.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 61,670.3 мянган төгрөг, хандив тусламжаар 158,288.8 мянган

07020066

төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй орлого авчээ.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 22 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 12 арга хэмжээг 100.0 хувь, 10 арга хэмжээг 70.0 хувь хэрэгжүүлсэн байна. Сумын Засаг дарга 92.0 хувиар биелэлтийг үнэлсэн. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 79.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	109,723.5	134,187.5
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	561,736.7	540,827.9
	Нийт хөрөнгийн дүн	671,460.2	675,015.4
	Нийт өр төлбөрийн дүн		9,487.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	671,460.2	665,528.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	671,460.2	675,015.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,262,592.6	857,703.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	586,089.2	863,635.1
	Үйл ажиллагааны үр дүн	676,503.4	(5,931.9)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	676,503.4	(5,931.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(5,043.1)	671,460.2
	Тайлант оны үр дүн	676,503.3	(5,931.9)
	Эцсийн үлдэгдэл	671,460.2	665,528.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	537,444.1	697,189.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	516,216.7	698,095.5
	Үйл ажиллагааны ЦМГ	21,227.4	(905.8)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(7,389.0)	(8,749.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	13,838.4	(9,654.8)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,838.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,838.4	4,183.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		645,174.2
	Урсгал зардал		645,174.2
	Хөрөнгийн зардал		-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		635,519.4
	Эрүүл мэндийн даатгалын сангаас		635,519.4
	Туслах үйл ажиллагааны орлогоос		
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	13,838.4	4,183.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		61,459.0
	Урсгал зардал		61,459.0
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		61,459.0
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		61,459.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 5.0 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагыг 5.0 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

Аудитаар залруулагдаагүй 18.01 сая төгрөгийг налдаа, зөрчлөөс 1.1 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 16.9 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. ЭМТ-ийн даргад Засаг даргын захирамжид зааснаас илүү хувиар тооцож 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.3-т "Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана", 3 дугаар зүйлийн 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Ээлжийн амралтын цалин 0.6 сая төгрөгийг цалинтай давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон

3. Өмнөх оны аудитын төлбөрийн акт 0.1 сая төгрөгийг шатахууны зардлаас төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.2 Албан шаардлага

1. Тендерт шалгараагүй 4 аж ахуйн нэгж байгууллагаас 8.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн

2. НББ-д бүртгэлтэй эм бэлдмэлийг түүвэрчлэн эмийн санчийн үлдэгдэлтэй тулгахад 82 ширхэг эм бэлдмэл дутуу, 5 төрлийн 4101 ширхэг эм бэлдмэл илүү байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна"

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан эмийн орлого зарлагыг нэр төрлөөр тулган баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Өглөг 8.7 сая төгрөгөөр нэмэгдсэн тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" 20.2.5. дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;- тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулах албан шаардлага хүргүүлсэн.

5. Төрийн аудитын байгууллагаас тогтоосон 2023 оны 01/118-07/118 дугаартай албан шаардлагуудыг хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй төсөв захирагчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг

хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Чандмань сумын Эрүүл мэндийн төв	1	5.0	-	-	1	5.0	1	5.0	-	-	-	-
Дүн	1	5.0	-	-	1	5.0	1	5.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Чандмань сумын Эрүүл мэндийн төв	8	18.1	3	1.2	4	16.9	-	-	1	1	-	-
Дүн	8	18.1	3	1.2	4	16.9	-	-	1	1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-